**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2025/178/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: П.Чанцалдулам<br>Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Нямцэцэг<br>Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn<br>Аудитор: Т.Баасанцэнд<br>Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn<br>Аудитор: Г.Тэлмүүн<br>Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/651

танай ______________-ны №______________-т

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АЛТАН-ОД ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөтөлбөр арга хэмжээний батлагдсан төсөвт тусгагдаагүй арга хэмжээг санхүүжүүлсэн, тайлант онд хэрэгжих боломжгүй ажил үйлчилгээний зардлыг олгосон, эдийн засгийн ангилал зөрчиж зардал гаргасан, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр арилжааны банканд данс нээсэн, бараа материалыг орлогод аваагүй зэрэг нийт 240,936.8 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11, 16 дугаар зүйлийн 16.5.3, 22 дугаар зүйлийн 22.2.3, 35 дугаар зүйлийн 35.4, 43 дугаар зүйлийн 43.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1, 14.4.2 дах заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн байх зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам */Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар хуучин нэршлээр/* нь 2019 онд Сансрын холбооны кэй юу зурвасын технологи ашиглан телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулан үзүүлэх төслийн гэрээг 10 жилийн хугацаатай байгуулж, гэрээний дүн, харилцагч талуудын үүргийн хэрэгжилттэй холбоотой зүйл заалтуудыг оновчтой тусгаагүйгээс тайлант онд гүйцэтгэгч байгууллагад төлөх 1,308,492.5 мянган төгрөгийн өр төлбөрийг шүүхийн шийдвэрээр бүртгэж, төсөвт дарамт үүсгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээний ашиглалтыг төр хариуцаж, Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз болон өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг үнэ төлбөргүй дамжуулна гэж заасны дагуу тус яамнаас нийт 6,434,196.2 мянган төгрөгийн санхүүжилтийг төрийн өмчит байгууллагуудад татаас шилжүүлгээр олгосон байна.

**Бусад асуудал**

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж хүргүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АТА9693 9006109
9023030583

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **592,718,567.04** | **752,091,499.40** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 40,181.00 | 30,181.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 40,181.00 | 30,181.00 |
| 3121 | Төгрөг | 40,181.00 | 30,181.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 40,181.00 | 30,181.00 |
| 33 | АВЛАГА | 1,000,000.00 | 31,694,513.40 |
| 335 | Бусад авлага | 1,000,000.00 | 31,694,513.40 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,000,000.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 31,694,513.40 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 421,970,612.24 | 236,116,020.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 421,970,612.24 | 236,116,020.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 169,707,773.80 | 294,443,035.00 |
| 354 | Хангамжийн материал | 169,707,773.80 | 294,443,035.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 17,117,098.00 | 12,984,120.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 123,355,327.80 | 111,256,440.80 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,896,700.00 | 46,693,400.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 6,467,400.00 | 6,643,700.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 16,871,248.00 | 116,865,374.20 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | - | 189,807,750.00 |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | - | 189,807,750.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,226,149,606.97** | **3,462,624,611.26** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,226,149,606.97 | 3,462,624,611.26 |
| 392 | Биет хөрөнгө | 658,065,815.20 | 551,067,741.23 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 59,900,000.00 | 6,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (59,900,000.00) | (2,750,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,382,992,268.26 | 1,343,633,360.78 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,020,438,212.87) | (997,324,993.45) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 439,060,937.13 | 421,287,537.55 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (143,549,177.32) | (219,778,163.65) |
| 393 | Биет бус хөрөнгө | 568,083,791.77 | 2,911,556,870.03 |
| 39301 | Програм хангамж | 792,137,200.00 | 3,850,739,343.60 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (479,753,408.25) | (1,042,032,473.59) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 961,110,000.00 | 948,310,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (705,409,999.98) | (845,459,999.98) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,818,868,174.01** | **4,214,716,110.66** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **1,308,492,450.00** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 1,308,492,450.00 |
| 413 | Өглөг | - | 1,308,492,450.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 1,308,492,450.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,818,868,174.02** | **2,906,223,660.67** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,818,868,174.02 | 2,906,223,660.67 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,818,868,174.02 | 2,906,223,660.67 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,757,598,116.78 | 1,818,868,174.02 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 61,270,057.24 | 1,087,355,486.65 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,818,868,174.01** | **4,214,716,110.66** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **15,746,020,692.80** | **25,162,677,548.62** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 363,322,737.20 | 86,082,144.62 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 363,322,737.20 | 86,082,144.62 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 361,681,137.20 | 31,443,463.64 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 356,540,136.70 | 31,443,463.64 |
| 120009 | Бусад орлого | 1,641,600.00 | 54,638,680.98 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 15,382,697,955.60 | 25,076,595,404.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 15,339,797,955.60 | 22,486,794,340.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 15,339,797,955.60 | 22,486,794,340.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 42,900,000.00 | 2,589,608,478.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 40,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,900,000.00 | 2,549,608,478.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | - | 192,586.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 192,586.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **15,684,750,635.56** | **23,279,763,450.93** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 15,684,750,635.56 | 23,279,763,450.93 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,192,986,233.80 | 12,238,679,852.42 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,871,131,745.23 | 3,285,714,748.88 |
| 210101 | Үндсэн цалин | 1,977,918,971.00 | 2,150,132,764.98 |
| 210102 | Нэмэгдэл | 324,346,185.23 | 486,689,483.90 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 241,185,000.00 | 380,111,000.00 |
| 210104 | Урамшуулал | 327,681,589.00 | 268,781,500.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 362,870,602.27 | 411,591,111.63 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 249,132,786.17 | 281,561,217.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,301,651.43 | 33,271,037.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 23,018,921.18 | 16,707,567.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,560,904.75 | 16,215,460.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 55,856,338.74 | 63,835,828.83 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 132,169,787.01 | 94,736,618.38 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 40,007,988.42 | 31,538,238.47 |
| 210302 | Түлш, халаалт | 20,447,974.59 | 39,048,283.91 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,115,094.00 | 7,950,096.00 |
| 210304 | Байрны түрээс | 63,598,730.00 | 16,200,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 87,003,577.21 | 137,817,494.44 |
| 210401 | Бичиг хэрэг | 32,691,170.00 | 38,092,110.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,474,640.00 | 5,852,286.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,521,209.21 | 18,503,438.44 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 660,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,939,026.00 | 45,324,970.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 29,384,690.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,489,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 61,230,569.00 | 19,966,650.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,926,380.00 | 759,850.00 |
| 210604 | Урсгал засвар | 57,304,189.00 | 19,206,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 148,406,937.00 | 172,556,041.60 |
| 210701 | Гадаад албан томилолт | 124,002,887.00 | 135,688,190.60 |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,570,800.00 | 36,022,301.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 2,833,250.00 | 845,550.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 307,829,248.94 | 2,977,535,916.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 279,542,338.94 | 2,958,881,293.60 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 95,523.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 27,030,000.00 | 17,240,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,136,900.00 | 1,319,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,220,854,767.14 | 5,138,761,270.89 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,202,709,297.40 | 4,097,339,498.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,675,659.00 | 8,970,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,007,469,810.74 | 1,032,451,772.89 |
| 212 | ТАТААС | 6,094,540,000.00 | 7,934,196,200.00 |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 5,697,040,000.00 | 6,434,196,200.00 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 5,697,040,000.00 | 6,434,196,200.00 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 397,500,000.00 | 1,500,000,000.00 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 397,500,000.00 | 1,500,000,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,397,224,401.76 | 3,106,887,398.51 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 1,490,242,268.12 | 1,487,356,414.47 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 1,490,242,268.12 | 1,487,356,414.47 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 166,517,701.00 | 267,231,800.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 113,417,701.00 | 25,081,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 53,100,000.00 | 60,150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 182,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,740,464,432.64 | 1,352,299,184.04 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,740,464,432.64 | 1,352,299,184.04 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **61,270,057.24** | **1,882,914,097.69** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 795,558,611.04 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 32,211.04 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө | - | 795,526,400.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-** | **(795,558,611.04)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **61,270,057.24** | **1,087,355,486.65** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **15,405,878,437.10** | **25,076,595,404.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,180,481.50** | **192,586.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 23,180,481.50 | 192,586.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 21,538,881.50 | - |
| 120009 | Бусад орлого | 1,641,600.00 | 192,586.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 15,382,697,955.60 | 25,076,402,818.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 15,339,797,955.60 | 22,486,794,340.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 15,339,797,955.60 | 22,486,794,340.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 42,900,000.00 | 2,589,608,478.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 40,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,900,000.00 | 2,549,608,478.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,000,000.00 | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 14,823,529,284.10 | 21,893,728,560.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 14,823,529,284.10 | 21,893,728,560.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,243,675,471.10 | 11,057,438,991.13 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,871,131,745.27 | 3,290,157,679.88 |
| 210101 | Үндсэн цалин | 1,713,195,393.76 | 2,155,516,527.87 |
| 210102 | Нэмэгдэл | 588,596,473.71 | 486,706,138.45 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 259,036,408.22 | 379,423,112.02 |
| 210104 | Урамшуулал | 310,303,469.58 | 268,511,901.54 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 362,870,602.27 | 409,591,111.63 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 249,132,786.17 | 281,561,217.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,301,651.43 | 33,271,037.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 23,018,921.18 | 15,245,736.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,560,904.75 | 15,677,291.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 55,856,338.74 | 63,835,828.83 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 131,074,787.01 | 94,736,618.38 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 37,594,848.42 | 31,538,238.47 |
| 210302 | Түлш, халаалт | 20,447,974.59 | 39,048,283.91 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,115,094.00 | 7,950,096.00 |
| 210304 | Байрны түрээс | 64,916,870.00 | 16,200,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 98,055,408.21 | 106,827,453.44 |
| 210401 | Бичиг хэрэг | 38,567,980.00 | 34,167,860.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,988,840.00 | 8,873,360.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 17,490,359.21 | 18,503,438.44 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,800,000.00 | 660,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 35,208,229.00 | 44,622,795.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,679,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 75,685,309.00 | 68,466,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,569,830.00 | 47,724,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 65,115,479.00 | 20,742,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 189,720,250.00 | 147,627,667.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 163,739,450.00 | 103,985,366.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 22,302,000.00 | 43,642,301.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 316,477,420.14 | 1,720,329,529.40 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 285,075,410.14 | 1,650,906,243.60 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 98,010.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 95,523.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 28,830,000.00 | 68,103,762.80 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,452,000.00 | 1,224,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,196,980,949.20 | 5,219,702,031.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,186,655,486.20 | 5,210,732,031.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,325,463.00 | 8,970,000.00 |
| 212 | ТАТААС | 6,094,540,000.00 | 7,934,196,200.00 |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 5,697,040,000.00 | 6,434,196,200.00 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 5,697,040,000.00 | 6,434,196,200.00 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 397,500,000.00 | 1,500,000,000.00 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 397,500,000.00 | 1,500,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,485,313,813.00** | **2,902,093,369.27** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 1,576,270,079.36 | 1,282,562,385.23 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 1,576,270,079.36 | 1,282,562,385.23 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 168,579,301.00 | 267,231,800.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 115,479,301.00 | 25,081,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 53,100,000.00 | 60,150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 182,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,740,464,432.64 | 1,352,299,184.04 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,740,464,432.64 | 1,352,299,184.04 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **582,349,153.00** | **3,182,866,843.60** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **3,182,876,843.60** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **582,330,153.00** | **3,182,876,843.60** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 582,330,153.00 | 3,182,876,843.60 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 582,330,153.00 | 3,182,876,843.60 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(582,330,153.00)** | **(3,182,876,843.60)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **19,000.00** | **(10,000.00)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **21,181.00** | **40,181.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **40,181.00** | **30,181.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,757,598,116.78** | **1,757,598,116.78** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 1,757,598,116.78 | 1,757,598,116.78 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 61,270,057.24 | 61,270,057.24 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,818,868,174.02** | **1,818,868,174.02** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 1,818,868,174.02 | 1,818,868,174.02 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 1,087,355,486.65 | 1,087,355,486.65 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **2,906,223,660.67** | **2,906,223,660.67** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **26,310,907,600.00** | **21,134,687,741.96** | **5,176,219,858.04** | **80.3** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **26,310,907,600.00** | **21,134,687,741.96** | **5,176,219,858.04** | **80.3** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **16,792,717,600.00** | **11,650,697,356.73** | **5,142,020,243.27** | **69.4** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **3,656,889,100.00** | **3,290,157,679.88** | **366,731,420.12** | **90.0** |
| Үндсэн цалин | 2,329,769,100.00 | 2,155,516,527.87 | 174,252,572.13 | 92.5 |
| Нэмэгдэл | 622,144,600.00 | 486,706,138.45 | 135,438,461.55 | 78.2 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 404,948,400.00 | 379,423,112.02 | 25,525,287.98 | 93.7 |
| Урамшуулал | 300,027,000.00 | 268,511,901.54 | 31,515,098.46 | 89.5 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **479,611,200.00** | **409,591,111.63** | **70,020,088.37** | **85.4** |
| Тэтгэврийн даатгал | 326,135,600.00 | 281,561,217.14 | 44,574,382.86 | 86.3 |
| Тэтгэмжийн даатгал | 38,368,800.00 | 33,271,037.56 | 5,097,762.44 | 86.7 |
| ҮОМШӨ-ний даатгал | 19,184,500.00 | 15,245,736.90 | 3,938,763.10 | 79.5 |
| Ажилгүйдлийн даатгал | 19,184,500.00 | 15,677,291.20 | 3,507,208.80 | 81.7 |
| Эрүүл мэндийн даатгал | 76,737,800.00 | 63,835,828.83 | 12,901,971.17 | 83.2 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **112,756,700.00** | **94,736,618.38** | **18,020,081.62** | **84.0** |
| Гэрэл, цахилгаан | 45,017,700.00 | 31,538,238.47 | 13,479,461.53 | 70.1 |
| Түлш, халаалт | 34,248,800.00 | 39,048,283.91 | (4,799,483.91) | 114.0 |
| Цэвэр, бохир ус | 9,587,000.00 | 7,950,096.00 | 1,636,904.00 | 82.9 |
| Байрны түрээс | 23,903,200.00 | 16,200,000.00 | 7,703,200.00 | 67.8 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **120,928,600.00** | **106,827,453.44** | **14,101,146.56** | **88.3** |
| Бичиг хэрэг | 34,188,700.00 | 34,167,860.00 | 20,840.00 | 99.9 |
| Тээвэр, шатахуун | 10,250,000.00 | 8,873,360.00 | 1,376,640.00 | 86.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 23,849,200.00 | 18,503,438.44 | 5,345,761.56 | 77.6 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,636,200.00 | 660,000.00 | 4,976,200.00 | 11.7 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 47,004,500.00 | 44,622,795.00 | 2,381,705.00 | 94.9 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **245,105,000.00** | **176,161,800.00** | **68,943,200.00** | **71.9** |
| Багаж, техник, хэрэгсэл | 165,100,100.00 | 155,419,700.00 | 9,680,400.00 | 94.1 |
| Урсгал засвар | 80,004,900.00 | 20,742,100.00 | 59,262,800.00 | 25.9 |
| **Томилолт, зочны зардал** | **157,389,100.00** | **147,627,667.00** | **9,761,433.00** | **93.8** |
| Гадаад албан томилолт | 103,986,000.00 | 103,985,366.00 | 634.00 | 100.0 |
| Дотоод албан томилолт | 49,780,300.00 | 43,642,301.00 | 6,137,999.00 | 87.7 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | 3,622,800.00 | - | 3,622,800.00 | - |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,035,030,400.00** | **1,681,308,015.00** | **2,353,722,385.00** | **41.7** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,952,965,800.00 | 1,610,896,243.60 | 2,342,069,556.40 | 40.8 |
| Даатгалын үйлчилгээ | 3,440,600.00 | - | 3,440,600.00 | 0.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 1,095,500.00 | 95,523.00 | 999,977.00 | 8.7 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 38,500.00 | - | 38,500.00 | 0.0 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 76,069,900.00 | 69,092,248.40 | 6,977,651.60 | 90.8 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,420,100.00 | 1,224,000.00 | 196,100.00 | 86.2 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7,985,007,500.00** | **5,744,287,011.40** | **2,240,720,488.60** | **71.9** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 7,974,634,700.00 | 5,735,317,011.40 | 2,239,317,688.60 | 71.9 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,372,800.00 | 8,970,000.00 | 1,402,800.00 | 86.5 |
| **ТАТААС** | **7,934,196,200.00** | **7,934,196,200.00** | **-** | **100.0** |
| **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | **6,434,196,200.00** | **6,434,196,200.00** | **-** | **100.0** |
| Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 6,434,196,200.00 | 6,434,196,200.00 | - | 100.0 |
| **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | **1,500,000,000.00** | **1,500,000,000.00** | **-** | **100.0** |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 1,500,000,000.00 | 1,500,000,000.00 | - | 100.0 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,583,993,800.00** | **1,549,794,185.23** | **34,199,614.77** | **97.8** |
| **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **1,291,044,500.00** | **1,282,562,385.23** | **8,482,114.77** | **99.3** |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | 1,291,044,500.00 | 1,282,562,385.23 | 8,482,114.77 | 99.3 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **292,949,300.00** | **267,231,800.00** | **25,717,500.00** | **91.2** |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 45,192,100.00 | 25,081,800.00 | 20,110,300.00 | 55.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 62,391,600.00 | 60,150,000.00 | 2,241,600.00 | 96.4 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 185,365,600.00 | 182,000,000.00 | 3,365,600.00 | 98.2 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **26,310,907,600.00** | **21,134,687,741.96** | **5,176,219,858.04** | **80.3** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **26,310,907,600.00** | **21,134,687,741.96** | **5,176,219,858.04** | **80.3** |
| Улсын төсвөөс санхүүжих | 26,310,907,600.00 | 21,134,687,741.96 | 5,176,219,858.04 | 80.3 |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | **100.0** |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **98** | **74** | **24** | **75.5** |
| Удирдах ажилтан | 23 | 8 | 15 | 34.8 |
| Гүйцэтгэх ажилтан | 71 | 64 | 7 | 90.1 |
| Үйлчлэх ажилтан | 4 | 2 | 2 | 50.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *[/төгрөгөөр/]*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **2,589,608,478.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **2,589,608,478.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **2,589,608,478.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **-** | **40,000,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 40,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **2,549,608,478.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,549,608,478.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **2,589,608,478.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **2,589,608,478.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 40,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,549,608,478.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

**3.1** Аудитаар нийт 102,560.9 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайланд үнэ шинэчлэн тогтоосон 54,638.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор, 32.2 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг данснаас хасахдаа үнэ төлбөргүй гарсан зардал-үндсэн хөрөнгөөр тус тус тайлагнасан байна. | 1 | 54,670.9 | | | 1 | 54,670.9 | 1 | 54,670.9 | | | | |
| Аж ахуйн 6 нэгжтэй байгуулсан 47,890.0 мянган төгрөгийн гэрээний урьдчилгаа төлбөрийг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй байна. | 1 | 47,890.0 | 1 | 47,890.0 | | | 1 | 47,890.0 | | | | |
| **Дүн** | **2** | **102,560.9** | **1** | **47,890.0** | **1** | **54,670.9** | **2** | **102,560.9** | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**3.2** Аудитаар нийт 240,936.8 мянган төгрөгийн 5 зөрчил[2] илэрснээс, 173,976.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 66,960.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| Урсгал төсвөөс худалдан авсан нийт 38,650.0 мянган төгрөгийн бараа материалыг орлого авалгүй шууд зардлаар бүртгэсэн байна. | 1 | 38,650.0 | - | - | - | - | 1 | 38,650.0 | - | - |
| Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр арилжааны банкинд данс нээсэн ба тайлант онд 8,360.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ гаргасан байна. | 1 | 8,360.0 | - | - | - | - | 1 | 8,360.0 | - | - |
| Хөтөлбөр арга хэмжээний батлагдсан төсөвт тусгагдаагүй дараах зардлуудыг гаргасан байна. Үүнд:<br>-хүний нөөцийн судалгааны зардал 49,000.0 мянган төгрөгийг цахим шилжилт арга хэмжээнээс,<br>-гэрээт ажилчдын цалин болон ахмад настанд хүндэтгэл үзүүлэхтэй холбоотой санхүүжилт 108,776.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаанаас, нийт 157,776.8 мянган төгрөгийн зарцуулалт гаргасан байна. | 1 | 157,776.8 | - | - | 1 | 157,776.8 | - | - | - | - |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардлаас зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 16,200.0 мянган төгрөгийн | 1 | 16,200.0 | - | - | 1 | 16,200.0 | - | - | - | - |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| танхимын түрээсийн зардлыг санхүүжүүлсэн байна. | | | | | | | | | | |
| Батлагдсан төсөвт тусгагдаагүй, тайлант онд хэрэгжих боломжгүй 19,950.0 мянган төгрөгийн нээлттэй мэдээллийн систем shilen.gov.mn-ий хөгжүүлэлтийн үйлчилгээг санхүүжүүлэн урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн байна. | 1 | 19,950.0 | - | - | - | - | 1 | 19,950.0 | - | - |
| **Дүн** | **5** | **240,936.8** | **-** | **-** | **2** | **173,976.8** | **3** | **66,960.0** | - | - |

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 517,287.0 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 395,462.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 121,825.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | |
| Цалингаас бусад таван саяас дээш зарлагын 26,796.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй, орлогын 5 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | 26,796.0 | 1 | 26,796.0 | - | - |
| **Дүн** | **1** | **26,796.0** | **1** | **26,796.0** | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | |
| "Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн систем"-ийг 2024 онд 2 аймагт нэвтрүүлсэн бөгөөд ЦХИХХЯ нь эдгээр системүүдийг программ хангамж дансанд бүртгэж, цаашид хэрэгжих аймгуудын цахим шилжилтийн системийн суурь болгон ашиглахаар ажиллаж байгаа ч гэрээнд оюуны өмчийг эзэмших, ашиглах талаар тодорхой заалт тусгаагүй байна. | 1 | - | - | - | 1 | - |
| Төсвийн төслийн саналыг боловсруулахдаа хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний зардлыг өмнөх онуудын гүйцэтгэлд суурилж, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөөгүй, арга хэмжээг | 1 | - | - | - | 1 | - |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| ажил үйлчилгээ, тоо үзүүлэлтээр дэлгэрэнгүй ангилан бэлтгээгүй, бөөн дүнгээр төсөвлөсөн байна. | | | | | | |
| Тайлант оны Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц /71302/ хөтөлбөрийн цахим шилжилт /80316/ арга хэмжээний батлагдсан төсвийн гүйцэтгэлээр бараа үйлчилгээний бусад зардлаас 8,034.3 мянган төгрөгийн тээвэр, шатахуун, 113,790.7 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан нь төсвийн хөтөлбөр, арга хэмжээний зардлын ангиллын бодит гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй байна. | 1 | 121,825.0 | - | - | 1 | 121,825.0 |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ижил төстэй ажил, үйлчилгээний төсөвт өртгийг хувааж, нийт 368,666.0 мянган төгрөгийн ажил, үйлчилгээг шууд худалдан авалтын аргаар бэлтгэсэн байна. /Үүнд: контент бүтээх 74,300.0 мянган төгрөг, арга хэмжээнд зориулсан тоног төхөөрөмж, хурлын заалны түрээс 294,366.0 мянган төгрөг/ | 1 | 368,666.0 | 1 | 368,666.0 | - | - |
| **Дүн** | **4** | **490,491.0** | **1** | **368,666.0** | **3** | **121,825.0** |
| **Нийт дүн** | **5** | **517,287.0** | **2** | **395,462.0** | **3** | **121,825.0** |